109

# ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 30 өдөр Дугаар б/84 Ховд

Х.Ганболдыг ажлаас чөлөөлж, шилжүүлэн ажиллуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. О.Эрдэнэсүрэнгийн хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусаж, ажилдаа орох болсон тул Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн дотоод хяналт, аудит хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Ганболдыг 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Х.Ганболдыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнээр шилжүүлэн ажиллуулсугай.

3. Х.Ганболдод Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-5-5 дахь шатлал буюу 791532 төгрөг /долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр/-өөр цалинг бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.ЭНХБОЛД

02-1088

D/Tush-B/84-Bo